

**МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ
МЭДЭГДЭЛ, 2026-2027 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН АНХНЫ
ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ЯВУУЛСАН ТАЛААРХ ТӨСВИЙН
БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2024 оны 10 дугаар
сарын 30-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч: Улсын Их Хурлын гишүүн З.Мэндсайхан

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн хуралдаанаар явуулж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу дагуу явуулж, хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцсэн болно.

Монгол Улсын Их Хурлын даргын 2024 оны 207 дугаар захирамжаар Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан бөгөөд Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед ажлын хэсэг болон гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гаргаагүй болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Ц.ДАВААСҮРЭН